

АГУУЛГА

<b>НЭГ 1.</b>	ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	2-5
<b>ХОЁР 2.</b>	ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	5-8
<b>ГУРАВ 3.</b>	Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт .....	9-12
<b>ДӨРӨВ 4.</b>	Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний хамрах хүрээ гол зорилт,хүрээ.....	13
<b>ТАВ 5.</b>	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	14-15
<b>ЗУРГАА 6.</b>	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	16
<b>ДОЛОО.</b>	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	17
<b>НАЙМ.</b>	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө ...	18
<b>ЕС.</b>	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	19
<b>АРАВ.</b>	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	20
<b>АРВАН НЭГ.</b>	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	21
<b>АРВАН ХОЕР.</b>	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр.....	22
<b>АРВАН ГУРАВ.</b>	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	23
<b>АРВАН ДӨРӨВ.</b>	Тухайн жилийн БОМТ, түүний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь.....	24
	"ТЭР БУМ МОД" үндэсний хөдөлгөөнд хувь нэмэр оруулах хувь нэмэр .....	25
	АРВАН ТАВ. Ашигласан материал.....	26

**Хавсралтаар:** 2023 онд хийгдсэн соруулах зориулалттай нүхэн ариун цэврийн байгууламж, ахуйн болон техникээс гарсан хаягдалын ангилан ялгах цэг, ангилсан байдлыг оруулж өглөө.

ХАВСРАЛТУУД

НЭГ.ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр

“Замын булаг алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл”

Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: “Шижир -Аранжин” ХХК


Регистрийндугаар: 5319331

Улсынбүртгэлийндугаар: 9011198130

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатархот, Баянзүрхдүүрэг, 26-р хороо, Натурын зам UB tower 409 тоот

Харилцахуугас: 99040498, 99118342

Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших Замын булагийн ордыг ашиглах нь Монгол улсад үйлдвэрлэлийн хэмжээнд алтны цэвдэгийн шороон ордыг далд аргаар олборлох анхны тохиолдол болж байсан бөгөөд энэ ч утгаараа уурхайн ашиглалтын бэлтгэл ажилд төлөвлөснөөс арай илүү хэмжээний цаг хугацаа, хөрөнгө зардал, хүч хөдөлмөр зарцуулагдсанаас гадна ашиглалтын үйл ажиллагаа удаашралтай байлаа. Иймээс 2017-2020 онуудад ТЭЗҮ-д нэмэлт тодотгол хийлгэж ил болон далд аргаар ашиглахаар тусган 2017 оноос эхлэн ил уурхайн ашиглалтын системээр зөвхөн дотоод овоолготойгоор олборлолтын үйл ажиллагаа явуулж байна.



“Замын булагийн” ордын байршлын тойм зураг

## 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Тусгай зөвшөөрлийн дугаар:

MV – 012665 А

Тусгай зөвшөөрөлтэй талбайн хэмжээ: 108.76 гектар

### 1.1. Талбайн булангийн солбицлууд:

Булангийн цэгийн дугаар	Өргөрөг, N	Уртраг, E
1.	46° 26' 37.62"	99° 59' 58.37"
2.	46° 26' 37.52"	100° 00' 00"
3.	46° 26' 37.59"	100° 00' 00"
4.	46° 26' 37.59"	100° 00' 0.51"
5.	46° 26' 1.59"	100° 00' 0.51"
6.	46° 26' 1.55"	99° 59' 40.48"
7.	46° 26' 21.54"	99° 59' 40.48"
8.	46° 26' 21.54"	99° 59' 15.47"
9.	46° 26' 51.55"	99° 59' 15.47"
10.	46° 26' 51.59"	100° 00' 0.51"
11.	46° 26' 50.55"	100° 00' 0.51"
12.	46° 26' 50.55"	99° 59' 59.56"
13.	46° 26' 50.38"	99° 59' 58.37"
14.	46° 26' 50.09"	99° 59' 56.8"
15.	46° 26' 49.61"	99° 59' 55.31"
16.	46° 26' 48.96"	99° 59' 53.98"
17.	46° 26' 48.16"	99° 59' 52.82"
18.	46° 26' 47.24"	99° 59' 51.89"
19.	46° 26' 46.22"	99° 59' 51.19"
20.	46° 26' 45.12"	99° 59' 50.77"
21.	46° 26' 44"	99° 59' 50.63"
22.	46° 26' 42.88"	99° 59' 50.77"
23.	46° 26' 41.78"	99° 59' 51.19"
24.	46° 26' 40.76"	99° 59' 51.89"
25.	46° 26' 39.84"	99° 59' 52.82"
26.	46° 26' 39.04"	99° 59' 53.98"
27.	46° 26' 38.39"	99° 59' 55.32"
28.	46° 26' 37.91"	99° 59' 56.8"

1.2. Уул зүй: Ашиглалтын талбай нь Хангайн нурууны өмнөд салбар уулсын нэг Жаргалантын нурууны төв хэсгийн өмнөд хажуугийн тусгай оргил болох Хүрэн чулуутын уулын (2742.0м) өмнөд бэл хормойн хэсгийг хамарч оршино. Энэхүү бүс нутаг нь далайн түвшинөөс дээш 2100-2700м-ийн хэлбэлзэлтэй өндөрлөг бүхий нурууны дундах налуу хотос

## 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

газрыг хамарна. Жаргалантын нурууны төв хэсгийн ноён оргил болох Мөнгөө хайрхан (2693.1м), Балгант хайрхан (2726.6м) уулуудын дунд байрлах Хайрхан давааны өврөөс эх авсан Хүрэн чулуут уулын бэлд байрлана.

Ашиглалтын талбайн дэвсгэр нутаг нь Хүрэн чулуутын уулын баруун өмнөд бэл хормойн хэсгийг хамарсан баруун урагшаа налуу байрлалтай, хуурай сайр жалгуудаар бага зэрэг хэрчигдсэн мөлгөр гадаргуутай хуримтлалын гүвээ гүдэнгүүд зонхилсон байдаг.

**1.3. Усан сүлжээ:** Судалгааны талбай нь гадаргын усан сүлжээ байхгүй. Хатаж ширгэсэн гол горхины гольдролын тогтолцоо хөгжсөн. Ашиглалтын талбайн баруун хойд зүгт 1,9 км-т 3 л/с ундратай, 118м-ийн гүнтэй худагтай бөгөөд ус нь тунгалаг, ахуйн хэрэгцээнд хэрэглэх боломжтой.

Гүний худгаас хүн малын ундны болон ахуйн хэрэглээнд, мөн техникийн зориулалтаар усыг ашиглаж байна. Жилийн хур тунадасны хэмжээ дунджаар 280 мм буюу зуны 6-7дугаар сард ихэвчлэн бороо орно.

**1.4. Ургамал зүй:** Хөрс, газар зүйн мужлалын хувьд хөрс-био уур амьсгалын Төв Азийн их мужийн Хангайн муж, өндрийн бүсжилтийн Хангай-Хэнтийн мужийн Өмнөдийн дэд мужид хамаардаг. Тухайн бүс нутаг хээр талын, хотгор, жижиг цав толгодын хөрсний бүлэгт хамаарах нутаг юм. Энд монгол шивэлз, монгол хялгана, монгол өвс, үнэгэн сүүлт, сорвоо, хазаар өвс, туяхан, дааган сүүл, божууль, мөлхөө хиаг, бага таван салаа, ишгэн шарилж, агь, далан түрүү, алаг башир, саарал шаваг зэрэг үетэн-алаг өвст, хялганат, хазаар өвс-хялганат уулын хээрийн ургамлууд зонхилно.

**1.5. Амьтны аймаг:** Тус бүс нутагт тарвага, оготоно, цөөн тоогоор урт сүүлт зурам, бор туулай зэрэг хөхтөн мэрэгчид, саарал чоно, үнэг, хярс зэрэг махчин амьтад, сар, тас, шонхор, харцага, элээ, хар хэрээ, бор шувуу зэрэг шувууд тохиолдоно. Мөн царцаа, олон төрлийн цохнууд, шоргоолж зэрэг шавьж амьдардаг.

**1.6. Уур амьсгал:** Судалгааны талбай нь эрс тэс уур амьсгалтай бүс нутагт хамаарна. Хамгийн хүйтэн үе 01-р сард  $-40^{\circ}\text{C}$ , хамгийн халуун сар нь 07-р сард  $+25^{\circ}\text{C}$  байна. Жаргалантын нуруу нь Хангайн нурууны өмнөд салбар уулсад хамаарах, харьцангуй өндөрлөг газар учир тал хээр, говийн нутгаас илүү хур тунадас унадаг. Ихэнх хур тунадас зуны улиралд 06, 08-р сард унадаг. Жилийн нийт хур тунадасны хэмжээ дунджаар 280мм.

Хаврын улиралд харьцангуй их салхитай. Салхи ихэвчлэн баруун хойноос чиглэлтэй, дундаж хурд нь 2.5-5м/сек салхилдаг. Салхины хурд бараг бүх сард тогтмол 14-18м/сек хүрдэг, харин хаврын улиралд 18-24м/сек хүртэл салхилах нь элбэг тохиолдоно.

**1.7. Цэвдэгшил ба газар хөдлөлт:** Тусгай зөвшөөрлийн талбай нь Монгол орны 1:1500000 масштабтай геокриологийн зурагт үзүүлснээр олон жилийн цэвдгийн ховор алаг цоог тархалттай бүслүүрт оршино. Энэ бүслүүрт олон жилийн цэвдгийн зузаан 6–50 м, зарим хэсэгт үүнээс ч зузаан, олон жилийн цэвдгийн температур нь 0 – ( $-1^{\circ}\text{C}$ ) орчим байна.

## 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хөрс нь 10-р сарын 15-ны үеэс өнгөнөөсөө хөлдөж улмаар 01-02-р сард хамгийн гүндээ хүрнэ. Мөн 04-р сарын эхнээс 06-р сарын дунд үе хүртэл өнгөнөөсөө гэсэж цэвдгийн үед тулна. Цэвдэгшил нь газрын гадаргаас доош 6-8 м-ээс эхэлж гүн болох тусмаа усжилт их болж цэвдгийн үе үргэлжилнэ. Ордын тусгай зөвшөөрлийн талбай нь газар хөдлөлтийн 2-4 баллын бүсэд байрлана.

### **ХОЁР.ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

**2.1. Дэд бүтэц:**Тус орон нутагт дэд бүтэц нь харьцангуй сайн хөгжсөн. Хүн амын нягтрал бага гол салбар нь мал аж ахуй юм. Өөр нэг салбар нь алтны уурхайнуудад түшиглэдэг. Баянхонгор аймаг нь газрын байрлалаар өндөрлөг уулархаг газар оршдог усны хагалбар муу тул газар тариалан хөгжөөгүй. Уурхайн талбайгаас 60 км-т оршдог Бөмбөгөр сум нь өндөр хүчдэлд холбогдсон мөн сургууль, цэцэрлэг, эмнэлэг, дэлгүүр зэрэг үйлчилгээний газруудтай. Уурхайн талбайгаас зүүн хойш 45 км-т Галуут сум орших бөгөөд тус суманд сургууль, цэцэрлэг, хүн эмнэлэг, дэлгүүр зэрэг үйлчилгээний газрууд ажилладаг. Энэ сум нь өндөр хүчдэлд холбогдсон. Харилцаа холбооны хувьд МЦХ–ны салбар болон Mobicom, Unitel-ийн үүрэн холбооны сүлжээтэй. Мөн ХААНболон Төрийн банкны салбар үйл ажиллагаа явуулдаг. “Баялаг-Орд” ХХК Mobicom-ийн антин тавьснаар уурхайн талбайн өндөрлөг газраас сүлжээ барьдаг болсон.

**2.2 .Зам харилцаа:** Тус талбай нь Улаанбаатар хотоос Баянхонгор хүртэл хатуу хучилттай болон сайжруулсан шороон замаар зорчино. Цааш талбай хүртэл мөн талбайн хэмжээнд авто тээврээр зорчиход ямар нэгэн бартаа саадгүй замын сүлжээ сайн хөгжсөн байдаг. Хээрийн замыг автомашинаар жилийн бүх улиралд ашиглах боломжтой.

Орд газраас зарим нэгэн суурин газар хүрэх зайг доор үзүүлэв:

• Улаанбаатар	-БУ	720 км
• Баянхонгор	-БХ	75 км
• Өвөрхангай	-БХ	290 км
• Галуут сумаас	-БУ	45 км
• Бөмбөгөр сумаас	-ЗХ	50 км
• Баян-Овоо сумаас	-БХ	50 км
• “Дөвөнтийн” алтны уурхайгаас-БХ		14км-т зайд байрладаг.

Хатуу хучилттай зам болон сайжруулсан шороон замтай бөгөөд, унаа хөсөг явахад ямар нэгэн саадгүй. Үйл ажиллагаа явуулж буй уурхайнууд цахилгааны хэрэгцээгээ дизель цахилгаан станцаар хангадаг.

**2.3. Уулын ажлын горим:**Тус уурхай нь жилийн турш тасралтгүй горимоор ажиллах бөгөөд жилдээ нийт 300 хоног бүрэн хүчин чадлаараа ажиллаж, бусад хугацаа нь баярын амралт болон болзошгүй үед зарцуулагдахаар төлөвлөсөн. Ил уурхайн ажилчид дулааны

## 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

улиралд хээрийн нөхцөлд 60 хоног ажиллуулж, 14 хоног гэрт нь амрах байдлаар вахтын системээр ажиллаж байна.

**2.4. Уурхайн суурин буюу кемп:** Уурхайн кемп нь төслийн талбайн баруун доод хэсэгт байрлах бөгөөд нийт 120 хүн нэг дор байрлах хүчин чадалтай бөгөөд нийт барилгуудыг сэндвичэн хавтангаар, вакум цонхтойгоор барьсан бөгөөд ажилчдын ая тухтай амьдрах шаардлагыг бүрэн хангасан тохилог, дулаан /дулааны систем бүхий/ байдлаар баригдсан.

Кемп нь дараах объектуудаас бүрдэж байна. Үүнд:

- Уурхайн ажилтнуудын амьдрах сууцнууд,
- Хоолны газар,
- Угаалгын газар,
- Оффисын байр,
- Бие засах газар,
- Агуулах,
- Хогийн цэг,
- Авто зогсоол,
- Биеийн тамирын талбай г.м объектууд хамаарна.

**2.5. Уурхайн барилга байгууламжууд:** Уурхайн талбайд дараахь объектууд байна. Үүнд:

- Уурхайн оффис
- Шатах тослох материалын агуулах болон шатахуун түгээх станц,
- Тэсрэх материалын агуулах,
- Ангор /засварын газар/,
- Гүйцээн баяжуулалтын байр,
- Харуул, хамгаалалтын байрууд г.м объектууд хамаарна.

### **2.6. Замын булагийн алтны шороон орд:**

Хайгуулын ажлыг “Замын булаг”-ийн ордод 2007-2008 онд Ч.Батбаяр, Э.Гансүх нар явуулж орд нь 650 м орчим урт, 220 м өргөнтэй нэг давхаргаас тогтох ба нийт 1524,3 т.м цооног өрөмдөж 0,2-0,4 м-ийн ахицаар нийт 3802 сорьц авч 8 хэсэгшилд 355,03кг алтны нөөц тогтоосон бөгөөд энэхүү ашигтай нөөцөд үндэслэн Замын булагийн алтны шороон ордыг ашиглах техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан.

Хүн амын ихэнх хэсгийг халх үндэстэн эзлэх бөгөөд нүүдлийн мал аж ахуй болон газар тариалан эрхлэн амьдарна.

Орд нь газар зүйн байрлалаараа жижиг толгодрохог, тал хээрийн бүсэд хамаарагдах бөгөөд эх газрын эрс тэс уур амьсгалтай, хамгийн дулаан нь 07-р сард +35 хэм, хамгийн хүйтэн нь нэгдүгээр сард -30хэм, жилд унах хур тунадасны ихэнх нь 7-8 сард унана.

Салхины чиглэл ихэвчлэн баруун хойноос 5-10 м/сек байх бөгөөд хавартаа салхины хүч 15-20 м/сек хүрч ширүүснэ.

Орд орчимд ихэвчлэн өвслөг, бутлаг ургамал ургах бөгөөд бор хүрэн өнгийн шороон хөрстэй. Амьтны аймгаас цөөн тоогоор үнэг, хярс, зурам зэрэг байна.



2.7. Ил уурхайд ажиллах үндсэн техник, тоног төхөөрөмж:

Уурхайн жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээ, ажиллах тоног төхөөрөмжийн бүтээл зэргээс хамааруулан уулын ажилд шаардлагатай дараах техник тоног төхөөрөмжүүд.



Зураг 3. Уулын үндсэн техник, тоног төхөөрөмжүүд

## ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛТ

### 3.1. Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл:

Ил уурхайн олборлолтын үйл ажиллагааны явцад хөрс хуулалт, тээвэрлэлтээс ил задгай хөрснөөс хийссэн тоос нь орчны агаарыг бохирдуулах эх үүсвэр болох юм. Мөн хуурайшилт ихтэй хавар, намрын улиралд агаарт дэгдэх тоосны хэмжээ харьцангуй их байгаа үед тоосжилт ихтэй зам талбайд урьд жилүүдийн адил усалгаахийгдэнэ.

### 3.2. Хөрсний эвдрэл, элэгдэл:

Ил уурхайн олборлолтын үйл ажиллагааны үед хөрс хуулалтын ажил явагдаж, газрын гүнээс гарах хөрсний овоолго газрын хэвлий дээр болон газрын ландшафтад өөрчлөлт орохоос сэргийлэн байгалийн унаган төрхийг хэвээр нь хадгалахыг зорин теникийн нөхөн сэргээлтийн ажлыг ашиглалтын сүүлийн жилүүдэд эрчимтэй хийж орон нутагт актаар хүлээлгэн өгөх, төлөвлөгөөт 2024 онд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг 0.8 гектор талбайдхийхээр төлөвлөсөн болно.

### 3.3. Усан орчинд үзүүлэх нөлөөлөл:

Уурхайн унд, ахуйн хэрэглээний усыг уурхайн талбайд байрлах 1 гүний худгаас хангаж ажиллана, технологийн хэрэглээний усыг гүний усыг хайрлаж, хамгаалах зорилгоор шүүрлийн усаар хангаж ажиллахаар төлөвлөсөн.

Унд ахуйн болон шүүрлийн усыг Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн лабораториор хяналт шинжилгээ хийлгэж мониторингийн ажлыг тогтмол хийж ажиллана.

### 3.4. Болзошгүй нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

Ашигт малтмал олборлох, уул уурхайн үйлдвэрлэл явуулах үед байгаль орчны төлөв байдал, орон нутгийн нийгэм, эдийн засагт нөлөөлж болох нөлөөллүүдийн хэлбэр, тэр нь эргэж нөлөөлөх эсэхийг болон нөлөөллийн үргэлжлэх хугацаа, түүний эрчимшил зэргийг тодруулахын тулд магадлан жагсаах аргыг өргөн хэрэглэдэг билээ. Магадлан жагсаах арга нь нөлөөлөл байна, байхгүй гэсэн зарчим дээр тулгуурладаг бөгөөд нөлөөлөл байвал “х”-ээр тэмдэглэв.

Байгаль орчны төлөв байдалд үзүүлэх болзошгүй нөлөөллийн хэлбэр, түүний эрчим ба үргэлжлэх хугацааг тодруулах үнэлгээг хүснэгт 1-д үзүүлэв.



**2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

*Хүснэгт 1.*

№	Байгаль орчны үзүүлэлтүүд	Нөлөөлөл			Хугацаа		Давталт		Эрчим		
		Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Бага зэрэг	Дунд зэрэг	Хүчтэй
<b>1. Биологийн төрөл зүйлийн оршин амьдрах нөхцөл</b>											
1.	Гадаргын усны нөөцийн өөрчлөлт										
2.	Газрын доорхи усны нөөцийн өөрчлөлт		x		x		x		x		
3.	Ойн нөөц										
4.	Хөрсний эвдрэл	x				x		x			x
5.	Геологийн тогтоц	x				x		x		x	
6.	Зэрлэг амьтдын орон зай	x			x			x		x	
7.	Уур амьсгал										
<b>2. Байгаль орчны аюул, осол</b>											
8.	Ашиглалт, хадгалалт, хэрэгжүүлэх явдалтай холбоотой буюу хорт бодисын байршлаас шалтгаалах аюул осол										
9.	Байгаль орчны аюул нэмэгдэх, магадлал нь ихсэх шалтгаан бий болох		x			x		x		x	
10.	Тухайн орон нутгийн байршил нь аюулт үзэгдлийн нөлөөлөлд эмзэг байх		x			x				x	
<b>3. Байгалийн нөөц, ашиглалт</b>											
11.	Гадаргын нөөц баялаг	x				x		x		x	
12.	Бэлчээрийн байдал	x				x		x		x	
13.	Газар тариалан										
14.	Эрдэс түүхий эдийн нөөц	x				x		x			x
15.	Эрчим хүчний нөөц		x		x			x		x	
<b>4. Байгаль орчны өөрчлөлт</b>											
16.	Усны чанар, хэмжээ /ундны ус/	x			x		x		x		
17.	Урсгал усны хэрэгцээ										
18.	Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх										
19.	Агаарын бохирдол	x			x		x			x	
20.	Хөрсний бохирдол, элэгдэл	x				x		x			x
21.	Дуу чимээний нөлөө		x		x			x		x	
<b>5. Нийгэмд үзүүлэх нөлөө</b>											
22.	Сургууль, эмнэлэг, цахилгаан болон усан хангамж, үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх нь										
23.	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх нь	x			x				x		
24.	Нүүлгэн шилжүүлэх асуудал гарах										
25.	Хүн амын орлого өөрчлөгдөх	x			x				x		

## 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

26.	Хүн амын тоо өөрчлөгдөх									
<b>6. Байгалийн үзэсгэлэнт нутаг, амралт, жуулчлал</b>										
27.	Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	x				x		x		x
28.	Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x		x		x
29.	Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх									
30.	Аялал жуулчлал, амрах нөхцөлд нөлөөлөх									
<b>7. Түүхийн дурсгалт зүйл, соёлын өв, археологи палентологийн олдвор</b>										
31.	Түүхийн дурсгалт зүйлд нөлөөлөх									
32.	Археологи, палентологийн олдворт нөлөөлөх									
<b>8. Эдийн засаг, байгаль орчин</b>										
33.	Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	x			x			x		x
34.	Орон нутгийн орлого нэмэгдэх	x			x			x		x
35.	Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x			x			x		x
36.	Ажлын байр нэмэгдэх	x			x			x	x	
37.	Ядуурлыг бууруулах дэмжлэг болох	x			x			x	x	
38.	Усжуулах гэх мэт газар ашиглалт нэмэгдэх									
	<b>Дун</b>	<b>18</b>	<b>5</b>	<b>-</b>	<b>13</b>	<b>10</b>	<b>3</b>	<b>17</b>	<b>10</b>	<b>8 5</b>

Тайлбар: x-болзошгүй нөлөөлөл, бөглөгдөөгүй нь тухайн үйлдвэрлэлд хамаагүй

**3.5. Шууд нөлөөлөл:** Болзошгүй нөлөөллийн ихэнх нь шууд нөлөөлөлд хамрагдаж байна. Шороон ордоос алт олборлохын тулд хөрс, хучаас хөрсийг хуулах, газрын хурдасыг эвдэж өөрчлөх, усыг ихээр ашиглах, геологийн тогтоцыг нь шууд эвдэж өөрчлөх, газрын гадаргын нөөц баялагт хомсдол үүсэх зэргээс шалтгаалж экологийн тухайн орчны системд нөлөөлөх, байгалийн тэнцвэр, унаган төрх өөрчлөгдөх зэрэг сөрөг нөлөөллөөс сэргийлэн техникийн нөхөн сэргээлтийг байгалийн унаган төрхийг хэвээр хадагалах зарчмыг баримтлана.

**3.6. Шууд бус нөлөөлөл:** Үүнд газрын доорхи усыг нилээд хэмжээгээр авч ашиглахад түүний чанарт гарах өөрчлөлт болон нэг дор олон хүнд механизм нэгэн зэрэг ажиллахад гарах дуу чимээ ихсэх зэрэг нөлөөлөл хамаарч байна. Үүнээс сэргийлж угаан баяжуулах усыг 30%-ийг нөхөн сэлбэлтээр, 70%-ийг эргэлтийн ус ашиглах бөгөөд дуу чимээнээс ажилчдын эрүүл мэндийг сэргийлэх зорилгоор дуу чимээний эрчмийг сулруулах чихэвч зүүлгэж хэвшүүлнэ.

### 3.7. Богино хугацааны нөлөөлөлд:

#### Сөрөг нөлөөлөл

- Уурхайн ус шүүрүүлэлтийн улмаас газрын доорх усны чанар, хэмжээ өөрчлөгдөх
- Хүнд механизмуудаас агаарт бохир утаа хаягдах
- Агаарт тоос шороо дэгдэх
- Дуу шуугианы нөлөөгөөр ая тух алдагдах
- Гадаргын өөрчлөлт бичил орчны уур амьсгалд нөлөөлөх зэрэг нөлөөлөл хамаарч байна.

Иймд утаа тоос шорооны бохирдлыг багасгах зорилгоор дизель хөдөлгүүрийн утааны янданд шүүлтүүр тавих, ухагдсан хөрс шороо, машин механизмд талхлагдсан орчны газрыг ялангуяа авто замыг хуурайшилт ихтэй үед усалж, чийглэж байх, ахуйн хатуу, шингэн хог хаягдлын цэгийг зөвшөөрөгдсөн ариутгах бодисоор тогтмол 7 хоногт 1 удаа ариутгаж, хуурай хог хаягдлыг Галуут сумын хогийн цэгт төвлөрүүлэн ажиллана.

#### Эерэг нөлөөлөл

- ✓ Татварын орлого
- ✓ Ажлын байр

### 3.8. Урт хугацааны нөлөөлөлд:

- Хөрсний элэгдэл, эвдрэл
- Гадаргын усны горимын өөрчлөлт
- Эрдэс түүхий эд бэлчээрийн нөөц багасах
- Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх алдагдах
- Амьтдын амьдрах орчин хязгаарлагдах зэрэг нөлөөлөл хамрагдаж байна.

Иймээс алт олборлолтын явцад байгалийн унаган төрхийг алдагдуулсаны дараа нөхөн сэргээлтийн ажлыг нарийн дэс дараалалтай гүйцэтгэсээр байгаа.

**Нөлөөллийн эрчим:** Ургамлын бүрхэвч, хөрсний эвдрэл, эрдэс түүхий эдийн нөөцийн болон байгалийн үзэсгэлэнт байдлын өөрчлөлт нь хүчтэй сөрөг нөлөөлөл болно. Газрын гадаргын нөөц баялаг болох ургамлын ургац, агаарын бохирдолтод дунд зэргийн эрчимтэй нөлөөлөх ба нийт нөлөөллийн 5 нь хүчтэй, 8 нь дунд зэргийн, 10 нь бага зэргийн эрчимтэйгээр нөлөөлөхөөр байна.

### **ДӨРӨВ.** Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

Энэхүү төслийг хэрэгжүүлэх үед технологийн онцлогоос хамааран газрын хөрс, түүний дээрх ургамал, газрын хурдас болон агаар мандалд тоос босох зэрэг сөргөөр нөлөөлөх тул байгаль орчны мониторингийг тогтмол хийх, түүнийг нөхөн сэргээх ажлыг байгаль хамгаалах төлөвлөгөө, санхүүжилтэндээ тусган гүйцэтгэнэ.

2024 онд Байгаль орчинд учруулж буй сөрөг нөлөөллийг багасгах, түүнийг бууруулах, хянах чиглэлээр Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулан Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан, БОМТөлөвлөгөөг баталсан байгууллага болох Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлж хянуулж батлуулан мөрдөж ажиллана.

2024 онд 0.8га газарт биологийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөгөөнд тусгав. Үүнд орон нутгаас дэвшүүлсэн зорилго, саналын дагуу дүйцүүлэн хамгаалах ажлыг чанартай хийж гүйцэтгэнэ.

Мөн Тэр бум мод тарих хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Замын булагийн ордын 2023 онд хийгдсэн биологийн нөхөн сэргээлтийн талбайн зах хэсэгт 1000 ширхэг мод тарина.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал, байгаль орчин, нийгмийн нөлөөллийг хянах хөтөлбөрийн хэрэгжилтийн зардлуудыг дараагийн бүлгүүдэд тусгасан болно.

**ТАВ.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, /төг/	Тоо хэмжээ	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Агаарын чанар	Уурхайн технологийн замыг шаардлагатай үед байнга услах чийглэх, ажлыг тогтмол хийж журнал хөтлөнө.	Уурхайн ашиглалтын идэвхтэй бүс	удаа	45000	13 удаа услана	585 000	2024 онд Хавар намрын хуурайшилттай өдрүүдэд	Агаархамгаал ахтай холбогдсон дүрэм, журам, бохирдуулагч бодисын хаягдлын стан дарт, хэмхэмжээний шаардлагыг хангах MNS 4585:2016
2.	Гадаргын болон газрын доорх усны нөөц	Гадаргын болон гүний усны бохирдол үүсэхээс сэргийлж ажиллана, дээж хэмжилт, сорьцлолт мониторинг хийх	Төслийн талбай баруун хойд хэсэгт цэвдэгийн хайлалтаас хуримтлагдсан уснаас	ширхэг	110 000	2 ширхэг дээж	220 000	2024 онд шүүрлийн тогтоол уснаас 8, 10-р сард тус тус 1 удаа 2ш дээжлэлт хийж итгэмжлэгдсэн лабораторт шинжлүүлнэ.	УтХ30.1.3. шаардлагад нийцүүлэн зайлуулах; MNS 4943:2015



**2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

3.	Газрын хэвлий	Олборлолтын явцад хөндөгдсөн газрын хэвлийг техникийн нөхөн сэргээлтээр дотоод овоолгоор дүүргэлт хийж ажиллана.	Уурхайн ашиглалтын идэвхтэй бүс	-	Ашиг-лалтын зардалд багтана.	-	Ашиг-лалтын зардалд багтана	Уурхайн хаалт хүртэл	Г.т.Х 35.3.2 Газрыг урашигтай, зохистой ашиглах, хамгаалах,
4.	Ургамлан нөмрөг	Барилга байгууламж ажилчдын хотхоны гадна талбай, ашиглагдсан талбайд биологийн нөхөн сэргээлт хийх ногоон байгууламж бий болгох зорилгоор мод сөөг тарьж ургуулна.	Төслийн талбайд: Бургас - Улиас-Хайлаас-	ширхэг	2000 2000 2000	400 300 300	800 000 600 000 600 000	2023 онд Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн зах хэсэгт 1000 ширхэг мод нэмж суулгана.	ХХЦСТХ: 7.2.1.иргэн, ажахуйн нэгж, байгууллагат огтоосонцэгэ эсбусад газарт хөрсийг хогха ягдлаар бохирдуулахгүй байх;
5.	Амьтны аймаг	Төсөл хэрэгжиж буй талбайн ойр орчим үлийн цагаан хулгана, хярс үнэгтэй	Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл байхгүй	-	-	-	-	-	Ховордсон, нэн ховордсон ан амьтан байхгүй болно.
<b>Нийт</b>							<b>2 805 000.0</b>		

Төлөвлөгөө гаргасан: “Шижир-Аранжин” ХХК-ийн

Хүрэн-Чулуутын уурхайн Байгаль орчны ажилтан ..... Д.Нямсүрэн

**ЗУРГАА. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /төг/	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Техникийн нөхөн сэргээлт	төлөвлөөгүй	га	-	-	-	=	-
2.	Биологийн нөхөн сэргээлт	Шимт хөрсөөр хучиж нутгийн болон худалдааны олон наст ургамлын үр суулгана.	га	0.8	444 300.00	3 554 400.00	2024 оны 06 - 07 -р сард багтааж үр суулгана.	MNS 5916:2008 Газаршорооны ажлын үед дүржил шимт хөрс хуулалт, хадгалах стандартыг баримтлана.
	<b>Нийт</b>			<b>0.8</b>		<b>3 554 400.0</b>		

Төлөвлөгөө гаргасан: “Шижир-Аранжин” ХХК-ийн

Хүрэн-Чулуутын уурхайн Байгаль орчны ажилтан ..... Д.Нямсүрэн

**ДОЛОО.БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /төг/	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Эвдэгдсэн газрын нөхөн сэргээлт	Гар аргаар алт олборлогчдын нөлөөллөөр эвдэгдсэн “ХАВЦГАЙТ” нэртэй талбайн 5.0 га-д техникийн нөхөн сэргээлт хийх	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний ажлын хүрээнд	5.0 га	836 120.00	4 180 600.00	2024 он 09, 10-р сард	MNS 5917:2008 Техникийн нөхөн сэргээлтийн ерөнхий шаардлагыг баримтлана.
	<b>Нийт</b>			<b>5.0</b>		<b>4 180 600.0</b>		

Төлөвлөгөө гаргасан: “Шижир-Аранжин” ХХК-ийн

Хүрэн-Чулуутын уурхайн Байгаль орчны ажилтан ..... Д.Нямсүрэн

**НАЙМ.НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /төг/	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Орон нутгийн иргэдийн хашаа сууц, өвөлжөө хаваржаа өртөх	Төсөл хэрэгжиж буй талбайд орон нутгийн иргэдийн хашаа сууц, өвөлжөө, хаваржааны байр ороогүй болно.	Төсөл хэрэгжиж уурхайн хаалт хүртэл	-	-	-	Төсөл хэрэгжиж буй талбайд орон нутгийн иргэдийн хашаа сууц, өвөлжөө, хаваржааны байр ороогүй болно.	-
	<b>Нийт</b>				<b>0.0</b>	<b>0.0</b>		

Төлөвлөгөө гаргасан: “Шижир-Аранжин” ХХК-ийн

Хүрэн-Чулуутын уурхайн Байгаль орчны ажилтан ..... Д.Нямсүрэн

**ЕС.ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /төг/	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Археологийн дурсгал	Газрын гадаргад ээртүүхс оёлын дурсгал, өвуурхайн талбайд байхгүй боловч олборлолтын явцад газрын хэвлийгээс гарчүйлажиллагааны улмаас асаюулд өртөж, устаж болзошгүй.	Монгол улсын холбогдох хуулиудын хэрэгжилтийг гчанд мөрдөж ажиллана. Олборлолтын явцад археологийн олдвор газрын хэвлийгээс илэрвэл газар шорооны ажлыг түр зогсоож, сумын удирдлагад мэдэгдэнэ.	-	-	-	Олборлолтын явцад археологийн олдвор илрээгүй болно. Хэрэв түүх соёлын дурсгалт өв илэрвэл холбогдох байгууллагуудад мэдэгдэж авран хамгаалах арга хэмжээг авна.	Соёлын өвийг хамгаалах тухай хууль 2014.05.15 ний өдрийн шинэчилсэн найруулга
2.	Палеонтологийн дурсгал	Олборлолтын явцад газрын хэвлийгээс гарчүйлажиллагааны улмаас асаюулд өртөж, устаж болзошгүй.	Олборлолтын явцад палеонтологийн олдвор газрын хэвлийгээс илэрвэл газар шорооны ажлыг түр зогсоож, сумын удирдлагад мэдэгдэнэ.	-	-	-	Олборлолтын явцад палеонтологийн олдвор илрээгүй. Хэрэв түүх соёлын дурсгалт өв илэрвэл холбогдох байгууллагуудад мэдэгдэж авран хамгаалах арга хэмжээг авна.	Соёлын өвийг хамгаалах тухай хууль 2014.05.15 ний өдрийн шинэчилсэн найруулга
<b>Нийт</b>					<b>0.0</b>	<b>0.0</b>		

Төлөвлөгөө гаргасан: “Шижир-Аранжин” ХХК-ийн

Хүрэн-Чулуутын уурхайн Байгаль орчны ажилтан ..... Д.Нямсүрэн



**2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

**АРАВ.ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /төг/	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Ил уурхайн аюулгүй ажиллагаа алдагдснаас осол аваар гарч болзошгүй	Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийг мөрдлөг болгон ажиллана.	Уурхайн хэмжээнд	1.0	40 000.0	ХАБЭА-н зардалд багтсан	2024 онд 1 удаа	Ил уурхайн аюулгүй ажиллагааны нийтлэг дүрэм ҮХСайдын 2003оны 98-р тушаалын хавсралт
	<b>Нийт</b>			<b>1.0</b>	40 000.0			

**Төлөвлөгөө гаргасан:** “Шижир-Аранжин” ХХК-ийн

Хүрэн-Чулуутын уурхайн Байгаль орчны ажилтан ..... Д.Нямсүрэн

**2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

**АРВАН НЭГ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөлөлийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөлийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төг/	Тоо хэмжээ	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Ахуйн	Ахуйн гаралтай хог хаягдлыг Галуут сумтай ( <b>гэрээ</b> ) хийж хамтран ажиллана.	Уурхайн хэмжээнд	удаа	1 200000	1.0	1 200 000	2024 оны 09-р сард Галуут сумын нэгдсэн хогийн цэгрүү ачуулна. ( <b>гэрээний дагуу</b> )	ХХТХ10.2.3. ажахуйн нэгж, байгууллаганы хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, ажахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах;
2.	Үйлдвэрийн	Үйлдвэрлэлээс гарсан хог хаягдлыг Баянхонгор аймгийн хоёрдогч түүхий эд авах цэгт тушаахаар төлөвлөлөө.	Уурхайн хэмжээнд	удаа	240 000	1.0	240 000	2024 оны 10-р сард өөрийн тээвэрээр тээвэрлэж Баянхонгор аймгийн “Цэвэр Хот” ААТҮГ хоёрдогч түүхий эд авах нэгдсэн цэгт гэрээний дагуу өгнө.	ХХТХ10.2.4. хог хаягдлаа зориулалтын хогийн савболон хаях цэгт эсхүл хог хаягда лцуулуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх;
<b>Нийт</b>						<b>2.0</b>	<b>1 440 000.0</b>		

Төлөвлөгөө гаргасан: “Шижир-Аранжин” ХХК-ийн

Хүрэн-Чулуутын уурхайн Байгаль орчны ажилтан ..... Д.Нямсүрэн

**2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

**АРВАН ХОЁР. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

№	Хяналт шиэжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал /төг/	Нийт зардал /төг/	Тайлбар	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>6</b>	<b>7</b>	<b>8</b>
1.	Агаар	Кемп, Баяжуулах хэсгээс	07, 10-р сард 2 цэгээс	2.0	130000	130000*4 ширхэг дээж = 520000	Баянхонгор аймгийн УЦУОШТ лабораториор шинжлүүлнэ.	MNS 4585:2016 стандартыг баримтлана.
2.	Хөрс	Шатахуун түгээгүүрийн орчим, Гадаад овоолгоос	06, 10-р сард 2 цэгээс	2.0	83500	83500*4 ширхэг дээж = 334000	Улаанбаатар хотноо итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлнэ.	MNS 6824:2020 MNS 3310:1991 MNS 5850:2019
3.	Ус /унд ахуйн/	Уурхайн ажилчдын унданд хэрэглэдэг худаг, үйлдвэрлэлийн худаг тус бүрээс	2024 онд 06, 10-р сард	2.0	75000	75000*4 ширхэг дээж = 300000	Улаанбаатар хотноо итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлнэ..	MNS 0900-2018 MNS 4943:2015 стандартыг баримтлана
4.	Ус /үйлдвэрийн/	Цэвэр, бохирын нуураас	2024 онд 06, 10-р сард	2.0	152900	152900*4.0 ширхэг дээж = 611600	Улаанбаатар хотноо итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлнэ.	MNS 4943:2015
	<b>Нийт</b>			<b>8.0</b>		<b>1 765 600.0</b>		

Төлөвлөгөө гаргасан: “Шижир-Аранжин” ХХК-ийн

Хүрэн-Чулуутын уурхайн Байгаль орчны ажилтан ..... Д.Нямсүрэн

**АРВАН ГУРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв. төг	Хэрэгжүүлэх хуваарь		Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024 он			
			Сар			
1	2	3		4	5	
1.	Байгаль орчны аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэсний дагуу гарсан дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах	150 000.00	06-10 р сарын хооронд		Байгаль орчны ажилтан Д.Нямсүрэн, Уурхайн ИТА-д	Байгаль орчны хууль, дүрэм, журам холбогдох стандартууд болон бусад шаардлагуудыг мөрдлөг болгон ажиллах
2	Сумын ИТХ-тай хамтран ажиллах	250 000.00	2024 онд		Захирал Д.Дариймаа	
	<b>Нийт</b>	<b>400 000.00</b>				

Төлөвлөгөө гаргасан: “Шижир-Аранжин” ХХК-ийн

Хүрэн-Чулуутын уурхайн Байгаль орчны ажилтан ..... Д.Нямсүрэн

**2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

**АРВАН ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал /төг/	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1.	Сумын оршинсуугчид, уурхайн байгаль орчны ажилтан	Өөрийн биеэр цаасан хэвлэмэл болон, фото зураг хэлбэрээр	БОХТ-ний биелэлт, түүний хэрэгжилт	2024 оны 03-р улиралд	260 000	БО-ны ажилтан Д.Нямсүрэн, Уурхайн ИТА-чид	Галуут сум Сүмбэрийн 2-р багийн төвд
2.	Баянхонгор аймаг БОАЖГ, Галуут сумын Байгаль орчны байцаагчид тус тус	БОХ-3.1 хэвлэмэл хэлбэрээр	Эвдэгдсэн газрын нөхөн сэргээлт	2024 оны 11-р сарын 20-нд	250000	БО-ны ажилтан Д.Нямсүрэн, Уурхайн ИТА-чид	Баянхонгор аймаг БОАЖГ, Галуут сумын Байгаль орчны албанд
3.	Баянхонгор аймаг БОАЖГ-т	2024 оны Байгаль орчны төлөвлөгөөний биелэлтийг цаасан, болон цахим хэлбэрээр өгнө мөн нөхөн сэргээлт хүлээлгэн өгөх	2024 оны менежментийн төлөвлөгөөний биелэлт, нөхөн сэргээлт	2024 оны 11-р сарын 20-нд	550000	БО-ны ажилтан Д.Нямсүрэн	Баянхонгор аймаг БОАЖГ-т
<b>Нийт</b>					<b>1060 000.0</b>		

**Төлөвлөгөө гаргасан:** “Шижир-Аранжин” ХХК-ийн

Хүрэн-Чулуутын уурхайн Байгаль орчны ажилтан ..... Д.Нямсүрэн



## “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНД ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх НҮБ-ийн индэр дээрээс дэлхийн нийтэд хандан Монгол Улс 2030 он гэхэд тэр бумаар тоологдох мод тарьж, ургуулах зорилт дэвшүүлээд байгаагаа мэдэгдэж, “Тэрбуммод” үндэсний хөдөлгөөнийг улс орон даяар эхлүүлсэн.

“Тэр бум мод” тарьж ургуулах нь зөвхөн дан ганц байгаль орчны салбарын ажил биш, монгол хүн болгон сэтгэл зүрхээрээ оролцох ёстой ажил гэдгийг онцлон тэмдэглэсэн.

“Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний аяны дагуу манай компани өөрийн тусгай зөвшөөрөл бүхий талбай болон кемпийн ногоон байгууламж дээр 2017 оноос хойш тарьсан 92 хувийн ургалттай байгаа нийт 4500 гаран мод, бутан дээрээ нэмж 2024 онд 1000.0 ширхэг мод бут тарьж уг хөдөлгөөнд хувь нэмэр оруулахаар төлөвлөлөө.

## 15. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- 15.1. Төслийн техник эдийн засгийн үндэслэл
- 15.2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээгээний дүгнэлт
- 15.3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан
- 15.4. Уул уурхайн салбарт мөрдөгдөж байгаа хууль, эрхзүйн баримт бичгийн эмхэтгэл, УБ, 2008
- 15.5. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны вэб сайт [eic.mn](http://eic.mn)
- 15.6. 2024 оны батлагдсан Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө

Аюултай хог хаягдлын агуулахад түр хураасан





Ангийн дизель, моторын суурийг цемэнтлэж өгсөн.





**Бие засах газрыг шинжилж стандартын дагуу болгосон**





ЭМ



Хог хаягдалын ангилан ялгасан байдал



# Галуут сумтай хийсэн хогны гэрээ



## ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ

2023 оны 06 сарын 29 өдөр

№03

Баянхошуу

Нэг талаас Баянхонгор аймгийн Галуут сумын Засаг даргын Тамгын газар (цаашид Засаг даргын Тамгын газар), түүнийг төлөөлж сумын **Татварын улсын байцаагч /М.Мандах/**, нөгөө талаас **Улаанбаатар хотын харъяат “Шижир аранжин” ХХК**-ийн иргэн/хуулийн этгээд (цаашид ашиглагч гэх), түүнийг төлөөлж **Уурхайн дарга** албан тушаалтай **Ш.Бямбасүрэн** бид дараахь нөхцөлөөр энэхүү гэрээг байгуулав.

### 1. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17-р зүйлийн 2.6, Хог хаягдлын тухай хуулийн 9.4, 10, 20.1, 20.2 дахь заалтыг үндэслэн хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх энгийн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, дахин боловсруулж эргүүлэн ашиглах, тээвэрлэх, булах болон орчны ариун цэврийг тогтмол цэвэр байлгах, цэвэр эрүүл орчинд ажиллаж амьдрах орчныг бий болгоход хамтран ажиллана.

### 2. Галуут сумын Засаг даргын Тамгын газрын эрх, үүрэг

2.1. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хуулийн дагуу хяналт тавьж ажиллах.

2.2. Иргэд аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдал гаргасны төлбөрийг төвлөрүүлэх

2.3. Иргэд аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдалаа зориулалтын цэгт хаяж байгаа эсэхэд хяналт тавих

2.4. Хог хаягдлын **төлбөрийн даалгаврыг** гүйлгээ хийхээс 7 хоногийн өмнө үүсгэж өгөх

### 3. Аж ахуйн нэгж байгууллагын эрх, үүрэг

3.1. Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг тогтсон хугацаанд цэвэрлэж, тээвэрлэн зориулалтын цэгт хаях

3.2. Хог хаягдлын төлбөр болох **1,200,000/нэг сая хоёр зуун мянга/** төгрөгийг үүссэн төлбөрийн даалгаврын дагуу төлөх.

### 4. Гэрээний хугацаа



4.1. 2023 оны 06 сарын 29 өдрөөс 2024 оны 06 сарын 29 өдөр хүртэл байна

#### 5. Бусад заалт

5.1.Талууд үйл ажиллагаандаа Монгол Улсын Иргэний хууль, бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

#### 6. Гэрээ хүчин төгөлдөр байх

6.1.Талууд гэрээнд гарын үсэг зурсан үеэс гэрээ хүчин төгөлдөр болно.

6.2.Гэрээг хуульд зааснаас бусад тохиолдолд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хугацаанаас өмнө гэрээг дуусгавар болгож болно.

#### 7. Талуудын хаяг:

Хаяг: Галуут сум Баянхошуу 6-р баг

Засаг даргын Тамгын газар

Татварын улсын байцаагч /М.Мандах/

Тамга, тэмдэг

Утас: 88036743

Хаяг:

Иргэн, аж ахуйн нэгжийн нэр:

“Шижир аранжин” ХХК

Регистр: 5319331

Хаяг: Улаанбаатар хот

Утас: 99194910

Факс:

Цахилгаан шуудангийн хаяг:

Гарын үсэг /Ш.Бямбасүрэн/

Тамга, тэмдэг

Баянхонгор аймаг “Цэвэр-Хот”-той хийсэн хаягдалын гэрээ

ЦЭВЭР ХОТ ОНӨААТҮГАЗРЫН  
ЗАХИРАЛ *М.Б.О.* Ц.БАЯСГАЛАН

оны 9 сарын 13

0320010010 ☎ 8147132

БАТЛАВ  
“ШИЖИР-АРАНЖИН ХХК”  
ЗАХИРАЛ *Д.ДАЙРИИМАА*

оны 9 сарын 13

УЛААНБААТАР ХОТ

ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

№ 274

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гэрээний зорилго: Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулж ачиж тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргэн ажиллах талаар иргэн, байгууллага, аж ахуйн нэгжтэй харилцан-тохиролцсоны үндсэн дээр холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажил гүйцэтгэх гэрээг байгуулах, хэрэгжүүлэх, дүгнэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү гэрээний эрх зүйн үндэслэл нь Иргэний тухай хуулийн 343-346, 350-353, 355, Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 6.4 дэх зүйл заалтууд байна.

1.3. Энэхүү гэрээний хэрэгжилтэд тухайн байгууллагын удирдах ажилтнууд болон сумын Засаг дарга, ажлын алба, хөндлөнгийн хяналтын байгууллага, хууль журам гэрээгээр тохирсон хэм хэмжээнд хяналт тавина.

1.4. Их цэвэрлэгээ болон бусад хог хаягдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх чиглэлээр сум болон төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй хамтран ажиллана.

Хоёр. Гэрээ байгуулагч талууд

2.1. Гэрээг нэг талаас “Цэвэр хот ОНӨААТҮГ”-ыг төлөөлж цаашид “тээвэрлэгч гэх” орлогын байцаагч ажилтай М.Алимаа нөгөө талаас “Тээвэрлүүлэгч гэх” “Шижир-Аранжин ХХК” төлөөлж Д.Нямсүрэн нар харилцан тохиролцон энэхүү гэрээг байгуулав.

Гурав. Тээвэрлэгчийн эрх үүрэг

3.1. Хог хаягдал тээвэрлэх чиглэл хуваарийг тогтоож Сумын Засаг даргаар батлуулж мөрдөн ажиллана.

3.2. Баянхонгор сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшил, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлыг тогтоосон хуваарийн дагуу зориулалтын тээврийн хэрэгслээр ачиж тээвэрлэн нэгдсэн хогийн цэгт хүргэн дарж булшлах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

3.3. Барилгын болон хортой, тусгай хог хаягдлыг холбогдох журмын дагуу тээвэрлэнэ.

3.4. Аж ахуйн нэгж, байгууллага уул уурхайн хог хаягдлыг ачиж тээвэрлэнэ.

3.5. Гүйцэтгэгч нь ажил үйлчилгээ үзүүлсэн төлбөрийг нэхэмжлэх, заасан хугацаанд төлөхийг шаардах эрхтэй (Зөрчлийн тухай хуулийн 7.6.4 дэхь заалт)

3.6. Ажил үйлчилгээний дагуу иргэдийн хог хаягдлын төлбөр тооцоо хийгдээгүй тохиолдолд хог хаягдлыг тээвэрлэхгүй ба түүнээс гарсан асуудлыг тус байгууллага хариуцахгүй.

3.7. Тухайн иргэн ахуй нэгжийн эзэн захирал ХХТХ-ийн 10.2.4-т заасны дагуу хог хаягдлаа зориулалтын хогийн сав болон цэгт хийх эрх бүхий байгууллагад шилжүүлэх. ХХТХ-ийн 10.2.1-т заасны дагуу ангилан ялгах

3.8. Хог хаягдлыг зориулалтын битүүмжлэлтэй аюулгүй ажиллагааны шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

Дөрөв. Тээвэрлүүлэгчийн эрх, үүрэг

4.1. Хог тээврийн гэрээний төсөлтэй танилцаж, хог хаягдлын тухай хуулийн 10.2.3-т заасны дагуу гэрээ байгуулах

4.2. Гэрээний дагуу хог хаягдлаа сардаа дуудлагаар хуваарийн дагуу ачуулах

4.3. ХХТХ-ийн 10.2.2-т заасны дагуу хог хаягдлыг түр хадгалах савны стандартыг хангасан хогийн савтай байх /галд тэсвэртэй материалаар хийгдсэн, хог хаягдал салхиар тархах,



хур тундасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн/, ХХТХ-ийн 10.2.1-т заасны дагуу ангилан ялгах

4.4 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг ХХТХ-ийн 10.2.7-т заасны дагуу тогтоосон хугацаанд төлөх

4.5 Тухайн аж ахуйн нэгж, байгууллага, дэлгүүр орчин тойрныхоо 50-100 метр хүртэлх зайг цэвэрлэж тээвэрлүүлэх.

4.6 Нийтийг хамарсан цэвэрлэгээ, иргэдийн бүлгээс зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцох, хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх

4.7 Хог хаягдлыг дэд бүтцийн шугам хоолойд хаяхыг хориглоно

4.8 Нийтийн эдэлбэр газар, ногоон бүсэд хог хаяхыг хориглоно

4.9 Хог хаягдлыг ил задгай шатаахыг хориглоно

4.10 Хог хаягдлын үйлчилгээтэй холбоотой санал гомдлыг 7044-4200 утсаар мэдээллэнэ.

#### Тав.Төлбөрийн нөхцөл

5.1 Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийг үндэслэн хог хаягдал гаргасны төлбөрийг /Баянхонгор сумын 2019.04.11 12\12 иргэдийн хурлын тогтоолоор батлагдсан төлбөрийн хэмжээгээр уурхай нь аюултай хог хаягдал 40000 -ийг сар бүрийн 28-ны дотор Төрийн сан дахь 100032000947 тоот дансанд буюу бэлнээр орлогын байцаагчид, тухайн баг хариуцсан жолоочид бэлэн мөнгөний баримтаар тушаана.

#### Зургаа. Гэрээний хугацаа

6.1 Гэрээ нь 2023 оны 01 сарын 01-ны өдрөөс 2023 оны 12 сарын 31-ны өдөр хүртэл 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

6.2 Гэрээний хугацаа дуусгавар болохос ажлын 10 хоногийн өмнө тээвэрлүүлэгч талаас гэрээг сунгах хүсэлт ирүүлээгүй тохиолдолд гэрээг хүчингүйд тооцож хог тээвэрлэлтийг бүрэн зогсооно.

6.3 Холбогдох байгууллагууд үйл ажиллагаагаа бүр мөсөн зогсоосон нь нотлогдсон тохиолдолд уг гэрээг дуусгавар болсонд тооцно.

#### Долоо. Талуудын хариуцлага, маргаан шийдвэрлэх журам

7.1 Талууд хагас бүтэн жилээр гэрээний биелэлтийг дүгнэж, цаашид илүү үр дүнтэй хамтран ажиллах боломжийг тодорхойж тооцоо нийлнэ.

7.2 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол хог хаягдлын тухай хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ.

7.3 Энэхүү гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд зөвшилцлийн замаар шийдвэрлэх бөгөөд шийдвэрлэх боломжгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### Найм. Бусад

8.1 Гэрээ нь талууд батлаж, гарын үсэг зурж тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

8.2 Талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Гэрээний нэмэлт өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

8.3 Энэхүү гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд нэг хувийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, нөгөө хувийг нь тус байгууллага хадгална.

ТЭЭВЭРЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

ЦЭВЭР ХОТ ОНОААТҮГ-Г  
ТӨЛӨӨЛЖИГЧИЙН БАЙЦААГЧ:

САНХУУ АЛИМАА

Хаяг: Номхонгор сум, Баянхонгор сум, ТТМ0112-А 8142132  
Дөвөнийн тээвэрний 2 дугаар давхарт

ТЭЭВЭРЛҮҮЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

"ШИЖИР- АРАНЖИН ХХК" ТӨЛӨӨЛЖ

Д.НЯМСҮРЭН

Хаяг: Галуут сум Сүмбэр 2-р баг  
Утас: 99819988



**“ЦЭВЭР – ХОТ” орон нутгийн өмчит ААТҮГ – нд Үйлдвэрлэл, техникээс гарсан хаягдалыг хүлээлгэн өгсөн.**





**“ЦЭВЭР – ХОТ” орон нутгийн өмчит ААТҮГ – нд 2 догч түүхий эд хуванцар, шил, лааз хүлээлгэн өгсөн.**





## Хог хаягдалыг ангилан ялгасан байдал



**“ЦЭВЭР – ХОТ” орон нутгийн өмчит ААТҮГ – нд Үйлдвэрлэл, техникээс гарсан хаягдалыг тушаасан.**



**БАЯНХОНГОР АЙМАГ  
“ЦЭВЭР ХОТ” ОРОН НУТГИЙН  
ӨМЧИТ ААТҮГ**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,  
Баянхонгор аймаг, 64101, УБД-8147132  
Утас 7044 4200

2023.10.30 № 87

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Хоёрдогч түүхий эд хүлээн  
авсан тухай Г

Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.4-д зааснаар хог хаягдалаа ангилан ялгаж 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдөр тус байгууллагад 3 шуудай хуванцар, 1 шуудай шил, лааз 1 шуудай, ажилласан масло 200 литр, маслын шүүр 6 ширхэг, түлшний шүүр 6 ширхэг, аккумулятор 3 ширхэгийг танай байгууллагын ажилтан Д.Байгалмаа нь хүлээлгэн өгсөнд талархаж байна.

Цаашид Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.1, 10.2.4-т заасны дагуу хог хаягдлаа ангилан ялгаж, тус байгууллагатай хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна.

ЗАХИРАЛ



Ц.БАЯСГАЛАН

642209044

toot A4-2023 on.doc



Уурхайн технологийн замын усалгаа.





**“ХОНГОРЫН ШУГУЙ” ХХК** – наар 1000.0 ширхэг модыг технологийн дагуу тариулсан



**Кемпийн ногоон байгууламж**





